

2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр

ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХҮСЭЛТЭЙ
ХУВЬ ХҮН/БАГ/, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД

Шинжээчээр хамтран ажиллах урилга хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газар нь “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” сэдэвт аудитад “Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланд шинжилгээ хийж, мэргэжлийн дүгнэлт гаргах” зорилгоор шинжээч сонгон шалгаруулж, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан хамтран ажиллахаар төлөвлөж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын хүрээнд хэрэгжих болно.

Шинжээч нь аудитын горим хэрэгжүүлэх явцад төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой нийт 300 гаруй хуулийн этгээдээс санамсаргүй түүврээр сонгосон 15 этгээдийн 2016-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн үр ашгийн тооцоо, шинжилгээ хийж, мэргэжлийн дүгнэлт гаргах бөгөөд ажлыг ҮАГ-АД/22-002 дугаар ажлын даалгаврын дагуу 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл хугацаанд гүйцэтгэх ба дараах ажилбаруудыг гүйцэтгэж, аудитын талбарын болон тайлагналын үе шатанд аудитын багийг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллана. Үүнд:

1. Санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн үр ашгийн тооцоо, шинжилгээ хийнэ. Үүнд:

- Санхүүгийн харьцааны шинжилгээ;
- Хөрвөх чадварын шинжилгээ;
- Ажлын цэвэр капитал (АЦК);
- Эргэлтийн харьцаа ЭХ;
- Үйл ажиллагааны шинжилгээ;
- Бараа материалын эргэц;
- Авлага цуглуулах дундаж хугацаа;
- Өрийн шинжилгээ;
- Ашигт ажиллагааны шинжилгээ;
- Хөрөнгө оруулалтын өгөөж (ROA);
- Хувьцаат капиталын өгөөж (ROE);
- Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS);
- Үнэ ашгийн харьцаа (P/E);
- Шинжилгээний Du Pont загвар;

2. Бүтээгдэхүүний борлуулалтын өртөг,

- Үнийн тооцоолол;
- Ногдол ашгийн тооцоолол, хуваарилалт;
- Бараа, материалын орцын норм, эргэц;
- Үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын байдалд судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;

3. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналтын тогтолцооны үр нөлөөнд дүгнэлт гаргах;

4. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал (Төсвийн бодлогын ил тод байдал, мөнгө ба санхүүгийн бодлогын ил тод байдал)-д дүгнэлт гаргах;

5. Шаардлагатай мэдээ, мэдээлэл цуглуулах, тооцоо, судалгаа, үнэлгээ хийх замаар аудитын багийн гишүүдэд мэргэжлийн арга зүйгээр хангах, зөвлөгөө өгөх:

Шинжээч нь ажлын даалгаварт тусгасан зорилгыг хэрэгжүүлэхдээ Төрийн аудитын стандарт, аудит хийх журам болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, зарчим, шаардлагыг мөрдлөг болгож, аудитын багаас гүйцэтгэлийн үе шатанд аудитад хамруулахаар сонгосон хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд мэргэжлийн түвшинд судалгаа, шинжилгээг онол, практикийн түвшинд эдийн засгийн үр ашгийн тооцоо, санхүүгийн шинжилгээ хийж, мэргэжлийн өндөр түвшинд чанартай гүйцэтгэж, мэргэжлийн дүгнэлт гарган үр дүнг тусгасан шинжээчийн тайланг бэлтгэнэ.

Шинжээчийн тайланд дүгнэлт гаргах явцад илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн дүн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудлын талаар бодлогын зөвлөмж, санал боловсруулж тусгана.

Шинжээч нь Үндэсний аудитын газартай гэрээ байгуулан ажиллах бөгөөд Аудитын гуравдугаар газрын аудитын багт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж, шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

Мэдүүлгээ ирүүлж буй этгээд нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт ирүүлэхээс гадна дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

Хуулийн этгээдийн хувьд:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын өргүй тухай тодорхойлолт/цахимаас татан авсан/;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт/цахимаас татан авсан/;
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл сүүлийн 3 жилээр

/2019,2020,2021 он/;

- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт /2020, 2021 он/

Хувь хүн/баг бол:

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Анкет /CV/;
- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
- Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ /нотариатаар

баталгаажуулсан/:

Шинжээч нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль салбарын бусад хуулийн хүрээнд санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн үр ашгийн тооцоо, санхүүгийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах эрх бүхий, мэргэшсэн, энэ чиглэлээр дүгнэлт гаргаж байсан ажлын дадлага, туршлагатай хувь хүн/баг/, хуулийн этгээд, баг байх байна.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллах ба аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллах ба тус зөвлөх үйлчилгээг багаар үзүүлнэ..

Шинжээчид тавигдах шаардлага, ажлын туршлага:

- Ажлын даалгаварт заасан ажлын зорилго, гүйцэтгэх ажил, үүргийн хүрээнд олон улсын мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж байсан туршлагатай;
 - Гадаадын хөрөнгө оруулалттай компани, банк, даатгал, бизнесийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдэд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан ажлын туршлагатай байх;
 - Санхүү, эдийн засгийн салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичигт судалгаа хийж, холбогдох мэргэжлийн дүгнэлт гаргасан туршлагатай байх;
 - Санхүү, эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний үндсэн чиг үүрэг хэрэгжүүлдэг байх.
 - Санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн үр ашгийн тооцоо, судалгаа хийж, дүн шинжилгээ боловсруулах мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй байх;
- Хуулийн этгээдийн боловсон хүчний тоо 5 буюу түүнээс дээш байх.

Ажиллах хүчний шаардлага:

Санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн үр ашгийн тооцоо, судалгаа хийж, дүн шинжилгээ хийх шинжээч, судлаач, эрдэмтэн, эрдэм шинжилгээний чиглэлээр мэргэшсэн байх.

Боловсон хүчин нь санхүү, эдийн засгийн ухааны магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй, эдийн засгийн үр ашгийн тооцоо, судалгаа, шинжилгээг төрийн өмчийн болон төрийн оролцоотой хуулийн этгээдэд хийж байсан туршлагатай бол давуу тал болно.

Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг гаргасан байх.

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгээ 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 09 цаг 10 минутын дотор цахим хаягаар [/tsend-ayushn@audit.gov.mn](mailto:tsend-ayushn@audit.gov.mn), [info@audit.gov.mn/](mailto:info@audit.gov.mn) pdf файл хэлбэрээр ирүүлнэ үү. Хариуцсан ажилтан: Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. Гар утас: 88051068

Захиалагчийн хаяг: 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр, 409 тоот өрөө. Үндэсний Аудитын газар. Утас: 51-26 35 33.
[www.audit.mn.](http://www.audit.mn)

